

СОЁМБО МЭДЭЭ

ҮЙЛ ЯВДАЛ

КОМИСС ХУРАЛДЛАА




Монгол Улсын Засгийн газрын Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяраар ахлуулсан Ардын хувьсгалын 100 жилийн ой, Төрийн далбааны өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хэсгийн бүрэлдэхүүн өчигдөр ээлжит хуралдаанаа хийв. Хурлын эхэнд ЗХЖШ-ын Ажиллагааны удирдлыгын газрын дарга, бригадын генерал С.Дашзэвэг Төрийн далбааны өдөрт зориулсан Цэргийн ёслолын жагсаалд оролцох бие бүрэлдэхүүнийг хэрхэн сонгох, тэдний жигдрэлт болон бэлтгэлийг хэрхэн

базаах талаар мэдээлэл хийж, санал солилцлоо. Мөн түүнчлэн цэргийн техникийн жагсаалын бэлтгэл ажлын явцын талаар хариуцсан албан тушаалтнууд танилцуулсан юм. Эдгээрээс гадна Цэргийн ёслолын жагсаалд хэрэглэгдэх материал хэрэгсэлийн хангалт, бэлтгэлтэй холбоотой асуудлуудыг ч хөндөв. Хурлын төгсгөлд Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр ажлын хэсгийн гишүүдэд хариуцаж ажил, хэрэгжүүлэх арга хэмжээний талаар үүрэг, чиглэл өглөө.

ЦЭРГИЙН АЛБАНЫ ХАРИЛЦАА ДҮРМИЙН ХҮРЭЭНД ЯВАГДАХ ЁСТОЙГ ОНЦЛОВ

ЗХЖШ-ын дарга, хошууч генерал Д.Ганзориг энэ сарын 4-ний өдөр цахимаар Төрлийн цэргийн командлал, Зэвсэгт хүчний нэгтгэл, ангиудын удирдлага болон дунд офицеруудад цэргийн алба, сахилга хариуцлага, дэг журам, ёс зүйн чиглэлээр үүрэг, даалгавар өглөө. Тэрээр уулзалтын эхэнд

анги, байгууллагад тактикийн түвшний үйл ажиллагааг шууд хэрэгжүүлэгчид юм. Та бидний цэргийн албаны өдөр тутмын үйл ажиллагаа амжилттай, сайн явж байгаа хэдий ч бас анхаарах асуудал байна. Нэгдүгээрт, цэргийн алба хаагчдын ёс зүй, сахилга хариуцлагын тухай юм.



техник, технологийн хөгжих дэвшлийг ашиглан эх орныхоо дөрвөн зүг, найман зовхист эх орноо батлан хамгаалах эрхэм үүргээ гүйцэтгэж байгаа алба хаагчидтайгаа уулзаж байгаадаа баяртай буйгаа дуулгалаа. "Өнөөдөр манай дунд офицерууд Зэвсэгт хүчний нэгтгэл,

Цэргийн албаны харилцаа зөвхөн дүрмийн хүрээнд явагдах ёстой бөгөөд үг, үйлдлээрээ зөв байх ёстой. Хуучин цагт жагсаалын өмнө хэн их орилж, хэн ёс бус үг хэллэгээр загнаж байна тэр мундаг цэргийн дарга гэж ойлгодог байсан.

(Үргэлжлэл нь арын нүүрт)

ЦАГ АГААР	
УЛААНБААТАР	
ӨДӨР	ШӨНӨ
-6°C	-19°C
ӨМНӨД СУДАН	
ӨДӨР	ШӨНӨ
38°C	26°C
АФГАНИСТАН	
ӨДӨР	ШӨНӨ
19°C	6°C

ВАЛЮТЫН ХАНШ		
ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD	2,845.0	2,858.0
EUR	3,420.0	3,486.0
CNY	438.20	442.50
RUB	37.83	39.58
JPY	26.40	27.06
KRW	2.48	2.60

КОВИД-19 МЭДЭЭ	
ШИНЭЭР БҮРТГЭГДСЭН	44
НИЙТ БҮРТГЭГДСЭН	3076
ЭДГЭРСЭН	2470
НАС БАРСАН	6

ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛЭГ	
ШИНЭЭР НЭМЭГДСЭН	33
ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БУЙ	205
ЭДГЭРСЭН	772

ӨРНИЙН ЗУРХАЙ	
2021.03.05. /БААСАН ГАРАГ/	
ХАВРЫН ТЭРГҮҮН ЦАГААН БАР САРЫН ДОЛООН УЛААН ХАР ХУЛГАНА ӨДӨР	
Үс засуулвал:	Идээ ундаа элбэг олдоно.
Наран ургах, шингэх:	07.25-18.42
Барилдлага:	Шид
Шүтэн барилдлага:	Авахуй
Суудал:	Гал

Аргын тооллын 3 дугаар сарын 5, Сугар гараг. Билгийн тооллын 22, Онгоц одтой, хар хулгана өдөр. Өдрийн наран 7.25 минутад мандан, 18 цаг 42 минутад жаргана. Тухайн өдөр луу, бич жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба бар, туулай жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр буян номын үйлд шамдах, бүтээл туурвил эхлэх, худалдаа арилжаа хийх, бизнес эхлэх, зэрэг дэв дэвших, гарагийг тахиж, хүүхэд үрчлэн авах, урлан бүтээхэд сайн. Улаа гаргах, хиншүү хярвас гаргах, төлгө тавих, морь уралдахад муу. Өдрийн сайн цаг нь хулгана, үхэр туулай, морь, бич, тахиа болой. Хол газар яваар одогсод зүүн урагш мөрөө гаргавал зохистой. Ичигсэд хөдлөх улирал (16 цаг 49 мин) эхэлнэ. Үс шинээр үргээлгэх буюу засуулбал эд, эдлэл, идээ, ундаа олно.

Д.Ганзориг: АЖИЛ АЛБА, ГЭР БҮЛ, ӨӨРИЙГӨӨ ХӨГЖҮҮЛ

Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга, хошууч генерал Д.Ганзориг өчигдөр Зэвсэгт хүчний 065 дугаар ангид ажиллалаа. ЗХЖШ-ын даргыг дагалдаж Зэвсэгт хүчний Агаарын цэргийн командлагч, бригадын генерал О.Энхбаяр Материал, техникийн газрын дарга, хурандаа М.Мөнхбаяр, нарын албаны хүмүүс ажилласан юм.

Тус ангийн захирагч, дэд хурандаа Ш.Цэрэнбат албаны хүмүүст ангийнхаа түүх, ололт амжилт, бүтэц орон тоо, энхийг сахиулах ажиллагаа болон бүтээн байгуулалт дахь оролцоо, сургалт бэлтгэл, бэлэн байдлыг дээшлүүлэхэд авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, тохижилт,

дараа ЗХЖШ-ын дарга, хошууч генерал Д.Ганзориг эх орныхоо агаарын хилийн халдашгүй дархан байдлыг нүд цавчилгүй хамгаалж байгаа тус ангийн үндсэн үүрэг гүйцэтгэлтэй танилцаж, зарим объектоор зочилж, төгсгөлд нь ангийн бие бүрэлдэхүүнтэй халдвар, хамгааллын дэглэмийг баримтлан уулзсан юм.

Тэрээр ангийн бүрэлдэхүүнд Зэвсэгт хүчний хууль, эрх зүйн шинэчлэл, цэргийн сургалт бэлтгэл, бүтээн байгуулалт дахь оролцоо зэрэг цаг үеийн мэдээлэл хүргэсэний дараа цэргийн алба хаагчид бүрийн анхаарах асуудлын талаар тодорхой үүрэг, чиглэл өгсөн юм. Уулзалтын эхэнд "Миний

яах гэж болсноо тунгаан бод. Зүгээр л сүр жавхаатай сайхан хувцас өмсөх гэж орж ирээгүй байх. Эцсийн зорилго нь эх орноо хамгаалах гэж энэ албыг сонгосон байж таарна. Тэгвэл цэргийн алба хаагчийн хүний заавал биелүүлэх үүрэг, даалгаврыг хэрхэн гүйцэтгэж чадаж байна вэ, өөрийгөө хэрхэн дайчилж, шинэчлэл, өөрчлөлтөд дасгаж байна вэ гэдгээ эргээд хараарай. Наад зах нь бие бялдраа чийрэгжүүлж, эрүүл мэндээ сайжруулахад онцгой анхаар. Энхийг сахиулах ажиллагааны сонгон шалгаруулалт явуулахад цөөнгүй алба хаагч өвчний учир хасагдаж байгаа нь нуух аргагүй үнэн. Биеийн тамир ч ялгаагүй. Хэрэв "Би ирэх жил энхийг

тархиа дүүргэх биш харин өөрийгөө хөгжүүлэх зэвсэг болгож ашигла. Англи хэлний гүнзгий биш ч гэсэн чөлөөтэй ярьж, чөлөөтэй бичиж сурах олон апплейкшн байгаа. Ядаж үүнд ашигла. Хэн ч байсан урсгалаараа л суудал бөглөсөн төдий явах эрхгүй. Цэргийн дүрэмт хувцсыг дүрмийнх нь дагуу цэвэрхэн өмс, жавхаалаг бай. Би яагаад хувь хүний хөгжлийн талаар яриад байна гэхээр Зэвсэгт хүчний хөгжил таны буюу хувь хүний хөгжлөөс эхэлнэ. Бэлтгэгдсэн олон цэргийн алба хаагчидтай байж, энэ салбар хөгжиж дэвшинэ. Өөрийгөө Зэвсэгт хүчний үнэтэй баялаг гэж үзээд хөгжүүлж, чадваржуулахад анхаар" гэлээ. Мөн тэрээр тус ангийн объектууд элдэгдэлд орсон,



бүтээлч ажлын талаар мэдээлэл өгөхийн зэрэгцээ тулгамдаж буй асуудлаа ч танилцууллаа.

Тухайлбал, тус ангийн ихэнх барилга, байгууламжууд 1964 онд баригдсан, насжилт өндөр байгаагийн хэрээр дулаан хадгалалт, эрүүл, аюулгүй орчин үргэлж хөндөгдөж байдаг талаар илтгэв. Мөн алба хаагчдын ар тал, хангалт, нийгмийн хамгаалал, дэг журам, сахилга, хариуцлагыг бэхжүүлэхэд авч хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ажил, арга хэмжээний талаар ч танилцууллаа. Үүний

хувьд Зэвсэгт хүчний 065 дугаар анги бол дэндүү танил орчин. Аав минь энэ ангид алба хааж байсан учраас танил, дотно орчин яахын аргагүй мөн" гээд алба хаагчдын анхаарах асуудлын талаар үргэлжлүүлэн ярьсан юм. Тухайлбал, "Цэргийн алба гэдэг өөрөө хамтын ажиллагаанд тогтдог салбар. Хэзээ ч ганцаараа алхдаггүй, ганцаараа гүйдэггүй, нэгэн зорилгын төлөө нэгэн зэрэг хамтдаа зүтгэдэг алба. Зүтгэхийн төлөө цэргийн алба хаагч та ямар байх ёстой вэ. Цэргийн алба хаагч

сахиулах ажиллагаанд оролцоно" гэж зорилго тавьсан бол эрүүл мэнд, бие бялдраа дээшлүүлэх зорилго, зорилт тавьж, түүнийхээ төлөө хичээсэн байх ёстой. Гэтэл урсгалаараа явж байгаад ороод шалгалтад уначихдаг. Ийм байж болохгүй. Ажил алба, гэр бүл, өөрийгөө хөгжүүлэх чиглэлээр бүгдийг нь төлөвлө. Төлөвлөөд үүнийхээ төлөө хичээ. Өнөөдөр манай цэргийнхэн дунд ухаалаг утасгүй хүн байхгүй байх. Ухаалаг утсаа зөвхөн facebook ухаж, хэрэгтэй, хэрэггүй мэдээллээр

зайлшгүй шинэчлэх шаардлага байгаа. Засварлаж, шинэчлэх нь улсын төсвөөс хамааралтай учир нэг амьсгаагаар биш шат дараатай шийдэгдэх асуудал гээд дэг журам, сахилга хариуцлагаа дээшлүүлэхэд хүн бүхэн онцгой анхаарахыг захиад удахгүй тохиох орчин цагийн Зэвсэгт хүчний 100 жилийн ойн баярын мэнд хүргэсэн юм.

Ахлах дэслэгч Д.БОЛОРМАА

ЦЭРГИЙН АЛБАНЫ ХАРИЛЦАА ДҮРМИЙН ХҮРЭЭНД ЯВАГДАХ ЁСТОЙГ ОНЦЛОВ

(Түрүүч нь тэргүүн нүүрт)

Одоо үүнийгээр өөрчлөх хэрэгтэй. Яагаад гэхээр дүрмийн бус харилцаа өөрөө дүрмийн бус харилцагч алба хаагчийг "төрүүлж" байна. Удирдагч хүн заавал хатуу, ширүүн үг, үйлдлээрээ бусдыг

цэргийн алба хаагчдын ёс зүй, дэг журам, сахилга хариуцлагын асуудлыг цогц байдлаар хариуцна. Гуравдугаарт, өөрийгөө хөгжүүлэхэд онцгой анхаар. Цэргийн алба тодорхой цаг хугацааны шалгуур, сурсан мэдлэг боловсрол, үр



захирдаггүй юм. Хоёрдугаарт, ажлын байрандаа архиан согтуурвал уучлаарай та халагдах болно. Хэдийгээр Зэвсэгт хүчний хүрээнд ажлын байрандаа архиан согтуурах асуудал багасаж, хумигдсан ч бид урьдчилан сэргийлэх ёстой. Ахуйн хүрээнд ийм байдал удаа дараа гаргасан ч ялгаагүй. "Миний тэр асуудлыг ЗХЖШ-ынхан мэдэхгүй өнгөрнө" гэж тооцож болохгүй. ЗХЖШ-т шинэ бүтэц орон тоогоор Цэргийн цагдаагийн хэлтэс шинээр байгуулагдсан. Энэ нь зөвхөн эргүүлийн үүрэг гүйцэтгэхгүй,

чадвар, сахилга хариуцлагаараа дэвшиж дээшилдэг тогтолцоотой. Энэ шалгууруудыг даваагүй буюу хугацаанаас өмнө цол нэмэх, албан тушаал ахих асуудлаар надад битгий хандаарай. Би хүлээж авахгүй" гээд дунд офицеруудад өөрийгөө хөгжүүлэх, албандаа хандах хандлагаа дээшлүүлэх, сахилга хариуцлагаа нэмэгдүүлэх зэрэг хэд хэдэн сэдвийн хүрээнд үүрэг, даалгавар өглөө. Тэрээр дараагийн удаа ахлах офицеруудтай цахим хурал хийх юм.

УЛСЫН ОНЦГОЙ КОМИССЫН ХУРЛААР ...

ШҮЛСНЭЭС КОРОНАВИРУС ИЛРҮҮЛЭХ ОНОШЛУУР НЭВТРҮҮЛНЭ

Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн эрдэмтэд "Ковид-19" халдварыг шүлснээс илрүүлэх шинэ оношлуур бүтээж, хэрэглээнд нэвтрүүлэхэд бэлэн болжээ. Энэ оношлуурын халдвар илрүүлэх мэдрэг болон өвөрмөц чанар нь туршилтаар 100 хувийн үзүүлэлттэй, шинжилгээний хариуг богино хугацаанд гаргах боломжтой аж.

Мөн сорьцыг 14 хоногийн хугацаанд хадгалах боломжтой

бөгөөд зардал нь 2-3 дахин хямд гэж Эрдэмтдийн зөвлөлийн дарга, АШУУИС-ийн захирал, доктор, профессор Н.Хүрэлбаатар танилцуулав. Монгол Улсын шадар сайд, Улсын Онцгой комиссын дарга С.Амарсайхан оношлуурыг албан ёсоор баталгаажуулж, шинжилгээ авч байгаа бүх лабораторийг түшиглэн нэвтрүүлэх, ялангуяа сорьцын хариуг богино хугацаанд гаргахаа эрчимжүүлэхийг Эрүүл мэндийн сайдад даалгажээ.



ШТАБЫН БЭЛТГЭЛ СУРГАЛТ ЯВАГДЛАА

016 дугаар нэгтгэл



Зэвсэгт хүчний 016 дугаар нэгтгэл нь 2019-2020 оны сургуулийн жилд Зэвсэгт хүчний штабын бэлтгэл сургалтаар

тэргүүлэгч нэгтгэл, анги шалгаруулах уралдаанд 2 дугаар байр, цэргийн сургалт бэлтгэлээр хошуучлагч ангийн болзол хангаж

Зэвсэгт хүчний тэргүүний ангиар шалгарсан амжилтыг үзүүлсэн. Тэгвэл 2020-2021 оны сургуулийн жилд "Штабын бэлтгэл сургалтыг

ХАТАН ИЖИЙ НАР ӨНӨӨДӨР ТОДОРНО



Монгол Улсын Батлан хамгаалах, Зэвсэгт хүчинд хөдөлмөр зүтгэл, оюун ухаан, чин сэтгэлээ зориулан хөдөлмөрлөхийн зэрэгцээ цэргийн ханийн үүрэг хүлээж, гэр бүл, үр хүүхдүүдээ ачлан тэтгэж, бат найдвартай ар тал нь болж, бахархан дуурайх амьдрал, ажил үйлсийн түүхэн замналыг бүтээж яваа ээжүүдээ алдаршуулах зорилгоор "Хатан ижий" хүндэтгэлийн арга хэмжээг

уламжлал болгон зохион байгуулдаг билээ.

2015 онд эхлэн ЦДБЭЧ-аас анхлан санаачилж, БХЯ, ЗХЖШ-тай хамтран зохион байгуулж жилээс жилд өргөжин тэлж буй "Хатан ижий"-г энэ жилийн сонгон шалгаруулалтад Батлан хамгаалах яамны харьяа байгууллагууд болон Зэвсэгт хүчний нэгтгэл, ангиас нийт 57 ээж өрсөлдөж байгаа юм.

Энэ жилийн Хатан ижий нар 56-75 насны ээжүүд бөгөөд 4-6 хүүхэд төрүүлж, эрүүл саруул, эрдэм боловсролтой өсгөн, хүмүүжүүлсэн, өөрөө төдийгүй хань, үр хүүхдүүд нь Зэвсэгт хүчинд алба хаадаг, Олон улсын энхийг сахиулах ажиллагаанд үүргээ нэр төртэй гүйцэтгэсэн зэрэг олон сайхан амжилт, бахархам амьдралын эзэд байх ажээ.

ЦАХИМ ШУУДАНД

ЭСЭЭ БИЧЛЭГИЙН АВАРГУУД ТОДОРЛОО

Өмнөговь аймгийн ЗДТГ-ын Цэргийн штаб

Орчин цагийн Зэвсэгт хүчин үүсэж хөгжсөний 100 жилийн ой, Монгол цэргийн өдрийн арга хэмжээний хүрээнд Монгол цэргийн нэгдсэн холбоо, "Отгонтэнгэр" их сургууль хамтран "Эрхмийн дээд монгол эр хүн" сэдэвт эсээ бичлэгийн уралдааныг зохион байгууллаа. Тус уралдааныг аймгийн хэмжээнд зохион байгуулсан бөгөөд I шатны шалгаруулалтад ирсэн эсээнүүдээс Даланзадгад сумын 1 дүгээр сургуулийн 12 дугаар ангийн сурагч П.Тайванбаяр, 4 дүгээр сургуулийн 12 дугаар ангийн сурагч Ө.Лхагвасүрэн, Манлай сумын Ерөнхий боловсролын сургуулийн сурагч Э.Цэнгүүнээ, О.Оюун-Эрдэнэ нарын эсээг шалгаруулж, Монгол цэргийн нэгдсэн холбоонд хүргүүлжээ.

Мөн ЗХЖШ-аас зохион байгуулсан "Монгол Улсын Зэвсэгт хүчин 100" гар зургийн уралдааны I шатыг 4 насны



ангиллаар зохион байгууллаа. Бага насны ангилалд I байрыг М.Сарангоо, дунд насны ангилалд Г.Тэмүүлэн, ахлах насны ангилалд Х.Намуунаа, оюутан насны ангилалд Б.Сарангуа нарын бүтээлүүд тус тус шалгарлаа. Шалгарсан

бүтээлүүдийг ЗХЖШ-ын Ажиллагааны удирдлагын газарт дараагийн шатны шалгаруулалтад оролцуулахаар хүргүүлэв.

Дэд хурандаа Д.УЛАМБАЯР



СОЁМБО СОНИН

"Соёмбо" сонин 97 дахь жилдээ хэвлэгдэж байна. Үндэслэгч нь: Н.ЖАДАМБА, Д.НАЦАГДОРЖ

Дарга, ерөнхий редактор Хурандаа САНЖМЯТАВЫН ТӨМӨРХУЯГ

Эхийг "Соёмбо" сонини редакцал бэлтгэв.

*Зар, рекламьг хямд нийтэлнэ.
*Зар, рекламьн үнэн зөв, эсэхийг нийтлүүлсэн байгууллага, хувь хүн хариуцна.
*Зохиогчийн үзэл бодол сонини нийтлэлийн бодлогод нийцэхгүй байж болно.
*Тус сонини мэдээллийг нэр заан ашиглаж болно.

Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, Офицеруудын ордон Индекс 10018

И-мэйл хаяг: Soyombo@mod.gov.mn Утас: 70001029